



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/129

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3, Тендерийн үнэлгээний хорооны 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэл, 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 02 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Баянзүрх дүүргийн Гал түймэр унтраах, аврах 63 дугаар ангийн сантехникийн болон авто тавиулангийн дээврийн засварын ажил гүйцэтгэгч сонгох ОБЕГ/201910084 дугаартай засварын ажил гүйцэтгэх тендерийг 41.327.539 (дөчин нэгэн сая гурван зуун хорин долоон мянга таван зуун гучин есөн) төгрөгт багтаан гүйцэтгэх тендерийн материал ирүүлсэн "Метро электрик" ХХК-ний тендер "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул гэрээ байгуулах эрх олгосугай.

2. Тендерийн хүчинтэй хугацаанд багтаан "Метро электрик" ХХК-тай гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээ дүгнэх ажлыг зохион байгуулахыг Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс (хурандаа Д.Даваасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА  Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

